

**ГАДААДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮЙЛДЭХ
ЗАХИАЛГАТ НИСЛЭГ**

- Энэ дүрэм ДБ-ийн сайдын 2002 оны 353 тоот тушаалаар батлагдаж, 2003 оны 02-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.
- Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд: /нэмэлт, өөрчлөлт хийгдээгүй/

313.1. Зорилго.....	2
313.2. Тодорхойлолт.....	2
313.3. Дүрмийн хамрах хүрээ.....	3
313.4. Захиалгат нислэгийн хязгаарлалт.....	3
313.5. Зөвшөөрлийн мэдэгдэл	3
313.6. Зөвшөөрөл хүссэн өргөдөл.....	4
313.7. Захиалгат нислэгийн гэрээ.....	5
313.8. Захиалгат нислэгийн хуваарийг өөрчлөх	5
313.9. Хариуцлагын даатгалын шаардлага	6
313.10. Зөвшөөрөл олгох	6
313.11. Нэмэлт мэдээлэл.....	6
313.12. Тээвэрлэлт нь Монгол Улсаас эхлэх захиалгат нислэг	7
313.13. Зорчигчдын нэрсийн жагсаалт	7
ХАВСРАЛТ А - ГАДААДЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ.....	9
ХАВСРАЛТ Б - ЗАХИАЛАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ	10

ГАДААДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮЙЛДЭХ ЗАХИАЛГАТ НИСЛЭГ

313.1. Зорилго

Энэ дүрэм нь гадаадын агаарын тээвэрлэгч /цаашид Гадаадын тээвэрлэгч гэх/-ийн гүйцэтгэх олон улсын захиалгат нислэгийн зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

313.2. Тодорхойлолт

Гадаадын агаарын тээвэрлэгч гэж олон улсын захиалгат нислэг гүйцэтгэх эрх бүхий гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг;

Захиалагч гэж Гадаадын тээвэрлэгчид нислэг захиалагч этгээдийг;

Захиалгат нислэг гэж захиалгын гэрээгээр зохицуулагдаж байгаа тогтмол бус, захиалгат (чартер) агаарын тээвэрлэлтийг;

Захиалгат нислэгийн 3 дугаар эрх гэж гадаадын тээвэрлэгчийн бүртгэлтэй улсаас эхэлж, гадаадын аль нэг улсад дуусгавар болгож буй захиалгат нислэгийг;

Захиалгат нислэгийн 4 дүгээр эрх гэж гадаадын тээвэрлэгч нь гадаадын аль нэг улсаас эхлэлтэй тээвэрлэлтийг өөрийн бүртгэлтэй улсад дуусгавар болгож буй захиалгат нислэгийг;

Захиалгат нислэгийн 5 дугаар эрх гэж тээвэрлэгч нь гадаад улсаас тээвэрлэлтийг эхлэн, өөрийн улсаар дамжин гүйцэтгэж буй эсэхээс үл хамааран, аль нэг гадаад улсад дуусгавар болгож буй захиалгат нислэгийг;

Холимог төлбөрт захиалгат нислэг гэж гэрээний дагуу, захиалгат нислэгийн төлбөрийг захиалагч болон зорчигчид хэсэгчлэн хариуцах нислэгийг;

Про рейта (Pro rata) захиалгат нислэг гэж тээвэрлэлтийн зардлыг зорчигчид нь хуваан төлөх нислэгийг;

Дан захиалгат нислэг гэж тээвэрлэлтийн зардлыг захиалагч хариуцах нислэгийг;

Жуулчны агент гэж захиалгат нислэгт зориулан бүлэг зорчигчдыг бүрдүүлэх болон тээвэрлэлтийг борлуулахад оролцож буй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг тус тус хэлнэ.

313.3. Дүрмийн хамрах хүрээ

Энэ дүрэм нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс буюу нутаг дэвсгэр рүү олон улсын захиалгат нислэгийг гүйцэтгэх эрх бүхий гадаадын тээвэрлэгчид хамаарна.

313.4. Захиалгат нислэгийн хязгаарлалт

(а) Гадаадын агаарын тээвэрлэгч нь ИНЕГ-аас захиалгат нислэгийн хүсэлтийг шийдвэрлэх явцад захиалгат нислэг гүйцэтгэхийг хориглоно.

(б) Захиалагч болон жуулчны агент нь ИНЕГ-ын зөвшөөрөлгүйгээр зорчигчийн аливаа захиалгат нислэгийг борлуулах, эсхүл сурталчлахыг хориглоно.

313.5. Зөвшөөрлийн мэдэгдэл

(а) Гадаадын агаарын тээвэрлэгч нь дараах тохиолдлуудад ИНЕГ-аас зөвшөөрлийн мэдэгдэл авсан байна:

1/ Монгол Улс уруу, эсхүл Монгол Улсаас гадагш үйлдэх захиалгат нислэгийн тавдугаар эрх авахад;

2/ Энэ зүйлийн (в), эсхүл (г)-д заасны дагуу ИНЕГ-аас урьдчилсан зөвшөөрөл тусгайлан шаарддаг захиалгат нислэг гүйцэтгэхэд;

3/ Захиалгат болон хуваарьт нислэгийн зорчигчдыг хамтад нь тээвэрлэх нислэг гүйцэтгэхэд (цаашид “хэсэгчилсэн захиалгат нислэг” гэнэ).

(б) ИНЕГ нь гадаадын агаарын тээвэрлэгчид олгосон тавдугаар эрхийн дагуу, энэ дүрмийн 313.10-т заасныг үндэслэн захиалгат нислэг гүйцэтгэх зөвшөөрлийн мэдэгдлийг олгоно. ИНЕГ-аас, шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн дагуу олгосон аливаа зөвшөөрлийг хүчингүй болгож болно.

(в) Гадаадын агаарын тээвэрлэгч нь аливаа захиалгат нислэгийг гүйцэтгэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө зөвшөөрөл хүссэн өргөдлийг (тайлбарын хамт, эсхүл тайлбаргүйгээр) ИНЕГ-т ирүүлнэ.

(г) ИНЕГ нь, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс, Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр захиалгат нислэг гүйцэтгэх гадаадын агаарын тээвэрлэгчдээс урьдчилсан зөвшөөрлийн мэдэгдэл авахыг шаардаж болно.

313.6. Зөвшөөрөл хүссэн өргөдөл

(а) Гадаадын тээвэрлэгч нь зөвшөөрөл хүссэн өргөдлийг захиалгат нислэгийг гүйцэтгэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-т ирүүлнэ /холбооны хэрэгслээр дамжуулан ирүүлж болно/.

(б) Монгол Улсын болон өргөдөл гаргагч улсын агаарын тээвэрлэгчдийн нислэг нь Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт, мөн дор дурьдсан зүйлд хамаарахгүй бол, өргөдөл нь ижил хэмжээний харилцан нислэг үйлдэх талаар хамтын ажиллагааны түвшинг тодорхойлсон бичиг баримтаас бүрдсэн байна:

1/ ИНЕГ нь тухайн улстай хамтын ажиллагааны талаар гэрээ байгуулаагүй бол;

2/ ИНЕГ-аас тухайн өргөдлийг судлах явцад хамтын ажиллагаанд ямар нэгэн өөрчлөлт гарсан бол.

(в) ИНЕГ нь аливаа өргөдөлд өгсөн хариу (зөвшөөрсөн, эсхүл татгалзсан)-г тэдгээрийн үндэслэл, бусад шаардлагатай мэдээллийг хяналт шалгалтын зорилгоор хадгална.

(г) Олон улсын нислэгийг зохион байгуулахтай холбогдолтой дараах нөхцлүүдийг “Аэро навигацийн мэдээллийн эмхэтгэл” (Jeppesen)-д нийтэлсэн байна:

- Захиалгат нислэг үйлдэх тухай албан ёсны хүсэлт;
- Гадаадын Иргэний нисэхийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл;
- Монгол Улсын болон гадаад улсын агаарын тээвэрлэгчдийн хооронд байгуулсан техникийн, газрын, арилжааны болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ;
- Нислэгийн зорилго;
- Захиалгат нислэгийн цагийн хуваарь;
- Агаарын хөлгийн ачаалалт /зорчигч, ачаа ба түүний ангилал/
- Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;
- ИКАО-д бүртгэлтэй томъёолсон тэмдэг;
- ИАТА-гаас авсан агаарын тээврийн компанийн томъёолсон код;
- Тээвэрлэгчийн хариуцлагын даатгалын баримт;
- Агаарын тээвэрлэгчийн арилжааны нислэгийн гэрчилгээ
- Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Агаарын хөлгийн даатгалын гэрчилгээ;
- Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;
- Дуу, чимээний хязгаарлалтын гэрчилгээ;
- Нисэх багийн үнэмлэх, эмнэлгийн гэрчилгээ;

(д) Өргөдөлд хавсаргасан мэдээллийг нийтэд дэлгэрүүлэхээс татгалзаж буй этгээд нь энэ тухай үндэслэлээ бичгээр ирүүлэх ба ИНЕГ нь тухайн мэдээллийг нийтэд дэлгэрүүлэхгүй байхыг батална.

(е) ИНЕГ нь захиалгат нислэгийн өргөдлийн хариуг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

313.7. Захиалгат нислэгийн гэрээ

(а) Захиалгат нислэгийг гэрээгээр зохицуулах бөгөөд гэрээнд гадаадын тээвэрлэгч болон захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

(б) Захиалгат нислэгийн гэрээнд дараах нөхцлүүдийг тусгана:

1/ гэрээ байгуулсан огноо, байгуулсан газар;

2/ гарын үсэг зурсан талуудын нэр, албан тушаал, гарын үсэг;

3/ нислэг үйлдэх он, сар, өдөр, нислэгийн чиглэл;

4/ агаарын хөлгийн маяг, түүний хүчин чадал;

-
- (i) зорчигчийн суудлын тоо;
 - (ii) ачааны багтаамж;

5/ захиалгат нислэгийн төлбөрийн ангилал, нийт төлбөр, нислэгийн болон нислэгийн бус төлбөрүүд, захиалгат нислэгт хэрэглэх тариф, төлбөрийн хэлбэр;

6/ захиалгат нислэгийн урьдчилсан төлбөрийн хэмжээ, төлбөр хийх, төлбөрийн баталгааг гаргасан этгээдийн нэр, хаяг;

7/ төлбөрийг буцаах болон торгууль ногдуулах нөхцөл;

8/ тээвэрлэгч болон захиалагчийн хүлээх эрх, үүрэг, нислэг саатаж цуцлагдсан үед хүлээх хариуцлага.

313.8. Захиалгат нислэгийн хуваарийг өөрчлөх

Гадаадын тээвэрлэгч нь зорчигч тээвэрлэх захиалгат нислэгийн хуваарийг дор дурьдсан нөхцлийн дагуу өөрчилнө:

1/ буцах нислэг байвал;

2/ зорчигч нь гэнэтийн нөхцөл шалтгааны улмаас захиалгат нислэгийн хугацаанаас өөр хугацаанд буцах шаардлагатай бол;

3/ захиалгат нислэгийг түргэвчлэх шаардлагатай бол;

4/ "Зорчигчоос үл шалтгаалах байдал" гэдэгт зорчигч, эсхүл түүний гэр бүлийн гишүүд гэмтэх, бэртэх, өвчлөх, нас барах, мөн цаг агаарын байдал, байгалийн гамшиг зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан газрын тээвэр, эсхүл дамжих нислэг саатах зэрэг шалтгаануудыг багтаана.

313.9. Хариуцлагын даатгалын шаардлага

Гадаадын тээвэрлэгч нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн, агаарын тээврийн нийтлэг эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн хариуцлагын даатгалын шаардлагыг хангасан байна.

313.10. Зөвшөөрөл олгох

(а) Захиалгат нислэг нь энэ дүрмийн шаардлагуудыг хангаж, нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзвэл ИНЕГ-аас зөвшөөрөл олгоно. Зөвшөөрлийн мэдэгдэлд ямар нэг болзол, эсхүл хязгаарлалт тавьж болно.

(б) ИНЕГ-аас Зөвшөөрөл олгохдоо дор дурьдсан хүчин зүйлүүдийг анхаарч үзнэ:

1/ Зөвшөөрөл нь Монгол Улстай байгуулсан Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн заалтуудад нийцэж буй эсэх;

2/ Гадаадын тээвэрлэгч болон Монголын агаарын тээвэрлэгчдийн хамтын ажиллагааны талаарх тохиролцоонд нийцэж буй эсэх ;

3/ Гадаадын тээвэрлэгч, эсхүл түүний зуучлагч буюу захиалгат нислэгийг зохион байгуулагч нь энэ дүрмийн заалтуудыг өмнө нь зөрчиж байсан эсэх.

(в) Зөвшөөрөл хүссэн өргөдлийг зохих журмын дагуу ирүүлээгүй тохиолдолд хянан үзэх хугацааг ИНЕГ-ын зүгээс онцлон зааж болно.

(г) ИНЕГ нь энэ дүрмийн 313.5-ын (в)-гийн дагуу зөвшөөрөл олгохоос татгалзвал энэ тухайгаа Өргөдөл гаргагчид албан ёсоор мэдэгдсэн байна.

313.11. Нэмэлт мэдээлэл

(а) Гадаадын тээвэрлэгч нь хавсралт А-гийн дагуу нэмэлт мэдээллийг бүрдүүлнэ.

(б) Захиалагч болон жуулчны агент нь хавсралт Б-гийн дагуу нэмэлт мэдээллийг бүрдүүлнэ.

313.12. Тээвэрлэлт нь Монгол Улсаас эхлэх захиалгат нислэг

(а) Тээвэрлэлт нь Монгол Улсаас эхлэх буюу Монгол Улс уруу үйлдэж буй олон улсын захиалгат нислэгийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх бол захиалгат нислэгийн бүх хөлсийг (эсхүл баталгааг) нислэгийг гүйцэтгэж эхлэхээс 10 хоногийн өмнө захиалагчаас авсан байна.

(б) Энэ зүйлийн (а)-гийн дагуу захиалгат нислэгийн тээврийн хөлсийг хугацаандаа төлөхийг шаардсан нөхцөлд, тээвэрлэлтийг Монгол Улсаас эхлэн гүйцэтгэж буй Гадаадын тээвэрлэгч нь нислэг эхлэхээс 10 хоногийн өмнө уг зорчигчдыг буцаан тээвэрлэх тээвэрлэгчээс захиалгат нислэгийн хөлсийг хураан авсан тухай бичгээр гаргасан баталгааг шаардана.

Баталгаа нь, захиалгат нислэгийн үндсэн нисэх буудал, он сар өдөр, хугацаа болон буцах нислэгийн үндсэн нисэх буудал, он сар өдөр хугацаа гэх мэт нарийвчилсан мэдээллийг багтаасан байх ба захиалгат нислэгийн зорчигчдын нэрсийн жагсаалтыг агуулсан байна.

(в) Монгол Улсаас тээвэрлэлт нь эхлэх нэг талын олон улсын нислэгийн захиалгат гэрээнд оролцож буй аливаа Гадаадын тээвэрлэгч нь тухайн нислэгийг гүйцэтгэж эхлэхээс өмнө зорчигчдыг буцаан тээвэрлэх тээвэрлэгчээс бичгээр баталгаа авсан байна.

(г) Захиалгат нислэгийн гэрээнд дурьдсаны дагуу Гадаадын тээвэрлэгчийн дансанд шилжүүлсэн төлбөрийг захиалгат нислэгийн төлбөр гэж тооцно.

313.13. Зорчигчдын нэрсийн жагсаалт

(а) Аливаа нэг талын болон хоёр талын нислэг эхлэхээс өмнө, захиалагч нь тээвэрлэх зорчигчид болон хүлээлгэнд байгаа зорчигчдын нэрс, хаяг, утасны дугаар бүхий мэдээллийг агуулсан жагсаалтыг тээвэрлэгчид бүрдүүлж өгнө. Нислэг эхлэхээс өмнө тухайн нислэгээр аялах зорчигчид өөрчлөгдвөл нэрсийн жагсаалтад уг өөрчлөлтийг оруулна.

(б) Захиалагчийн эрх бүхий төлөөлөгч нь зорчигчдын нэрсийн жагсаалтад гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

(в) Гадаадын тээвэрлэгч нь захиалгат нислэгийн зорчигчдын нэрсийн жагсаалтын талаар ИНД-331-ийн шаардлагыг хангана.

ХАВСРАЛТ А - ГАДААДЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

1. Тээвэрлэгчийн нэр:
2. Төлөвлөж буй нислэг эхлэх хугацаа:
 - (а) явах
 - (б) буцах
3. Төлөвлөсөн нислэгийн маршрут:
 - (а) явах _____ аас _____ хүртэл
 - (б) буцах _____ аас _____ хүртэл
 - (в) завсрын буулт хийх нисэх буудал болон нислэгийн бусад цэг:
4. Агаарын хөлөг:
 - (а) ашиглах агаарын хөлгийн маяг
 - (б) суудлын багтаамж
 - (в) тээвэрлэх зорчигчдын тоо
5. Захиалгат нислэгийн нийт төлбөр:
6. Нэмэлт үйлчилгээ:
 - (а) тээвэрлэгч нь нэмэлт үйлчилгээ үзүүлэх эсэх
Тийм [] Үгүй []
 - (б) хэрэв “Тийм” бол нэмэлт үйлчилгээний төрөл болон бусад мэдээлэл:

7. Захиалагчийн нэр, хаяг:
8. Захиалгат нислэгийн зорилго:
9. Захиалгат нислэгийн гэрээг байгуулсан огноо:
10. Тарифыг жуулчны агентад мэдэгдсэн эсэх

Мэдээллийг бүрдүүлсэн:

/албан тушаал, гарын үсэг/

ХАВСРАЛТ Б - ЗАХИАЛАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

1. Захиалагчийн нэр хаяг
2. Захиалагчийн эрхэлдэг үйл ажиллагаа:
3. Байгуулагдсан огноо
4. Захиалгат нислэгийн талаар ямарваа нэгэн тайлбар байгаа эсэх
Тийм [] Үгүй []
5. Дараах мэдээллийг багтаасан, тээвэрлэх зорчигчдын нэрсийн жагсаалтыг хавсаргах:
(а) нэр, хаяг болон утасны дугаар
6. Захиалгат нислэгт оролцогчдод тавигдаж буй шаардлага:

7. Захиалгат нислэгийн зорчигчдыг хэрхэн бүрдүүлсэн бэ (баримтуудыг хавсаргах)
8. Захиалгат нислэгийн зорчигчдын тоо үүнээс:
(1) захиалагчийн бүрдүүлсэн зорчигчид:
(2) жуулчны агентийн бүрдүүлсэн бүлэг зорчигчид:
(3) бусад:
9. Хэрэв захиалгат нислэгт жуулчны агентаас бусад зуучлагч оролцож байгаа бол тэдгээрийн нэр хаяг үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох:
-----10
. (Про рейта хураамж) х (Зорчигчдын тоо) = \$ (Захиалгат нислэгийн тооцоот үнэ)
11. Бусад нэмэлт төлбөр байгаа эсэх:

Тайлбарлах:

(а) Нийт хүлээн авах үнэ: \$_____.

Тооцоот зардал, агаарын хөлгийн захиалгыг оролцуулах :

Төлөгдөх хэмжээ:

(б) Нийт зардал: \$_____.

/(а) болон (b)-ийн хооронд ялгаа байгаа бол тайлбарлах/

12. Хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй тээвэрлэгдэх зорчигч байгаа эсэх (2 хүртэл насны хүүхдээс бусад) Тийм [] Үгүй []
13. Захиалгат нислэгийн төлбөрийг тээвэрлэх зорчигч тус бүрт адил тэнцүү хуваах эсэх
Тийм [] Үгүй []

14. Нислэгийн нэг талын зорчигчдын тоо болон явсан, ирсэн нислэг тус бүрт тусгаарлан заах:

а. Явах

б. Ирэх.....

в. Нийт.....

15. Бүлэг зорчигчид байгаа эсэх / явах/ирэх чиглэлд/ Тийм [] Үгүй []

16. Захиалагч нь ИНЕГ-ын холбогдох дүрэмтэй танилцсан эсэх Тийм [] Үгүй []

17. Хавсаргасан баримт бичгийн хуудасны тоо.

Захиалагчийн баталгаа

Би, _____ (нэр) болон _____ (нэр) захиалагч энэхүү захиалгат нислэгийн гэрээний дагуу гүйцэтгэхийг баталгаажуулж байна.

Мэдээллийг бүрдүүлсэн:

/албан тушаал, гарын үсэг/

* * *